

БАТЛАВ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА *Б.ОТГОНЧИМЭГ*
2024 оны ... сарын ... өдөр

МОНГОЛ УЛСАД ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА ҮҮСЭЖ ХӨГЖСӨНИЙ 70 ЖИЛИЙН ОЙГ
ТОХИОЛДУУЛАН ОРОН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮТЭЭЛЧ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны 03-р сарын 18 ны өдөр

д/д	ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХУГАЦАА	ХАРИУЦАХ АЛБАН ТУШААЛТАН
1. САЛБАРЫН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ				
1.1	Газар зүйн нэрийн тодруулалтын ажлыг хийж гүйцэтгэх, газар зүйн нэрийн тодруулалтын үр дүнгээр шинээр тогтоогдсон газар зүйн нэрийн жагсаалтыг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх.	Сумдын Газар зүйн нэрийн ажлын хэсгийг хуралдуулах.	2024.04.01	Газрын удирдлагын хэлтэс
		Шивээговь сумын газар зүйн нэрийн суурин судалгааны ажлыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэх.	2024.04.10	
		Сүмбэр, Баянтал сумын газар зүйн нэрийн суурин судалгааны ажлыг эхлүүлэх.	2024.04.15	
1.2	Газрын төлбөрийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор уул уурхайн ашиглалт явуулж байгаа уурхайн эдэлбэр газарт магадлан хэмжилтийг хийх.	Шивээ-Овоо ХК-ийн уурхайн ашиглалт явуулж байгаа эдэлбэр газарт хяналтын хэмжилт хийх.	2024.05.20	Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн
1.3	Уул уурхайн газарт хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах, зөрчилтэй нэгж талбарын судалгааг гаргах, нөхөн сэргээлт хийх ажлыг зохион байгуулах.	Шивээ-Овоо ХК-ийн уурхайн ашиглалт явуулж байгаа эдэлбэр газарт хяналтын хэмжилт хийх, газрын нэгдмэл сангийн ГТ-6, ГТ-7 тайланг бодитоор нягтлах.	2024.05.20	Газрын удирдлагын хэлтэс, Газар, геодези зураг зүйн улсын байцаагч
1.4	Уул уурхайн зориулалтаар газар эзэмшиж, ашиглаж байгаа газар эзэмшигч, ашиглагчдын гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулах.	Шивээ-Овоо ХК-ийн газар эзэмших гэрээг дүгнэх.	2024.05.20	Сумдын Газрын даамал
1.5	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад салбарын хууль тогтоомж, Газрын удирдлагын цахим системийн үйл	Мэдээллийн цагийн хуваарь гарган Газрын даргаар батлуулан хэрэгжүүлж ажиллах.	2024.03.20- 2024.05.01	Газрын удирдлагын хэлтэс

1.7	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил газрыг 10%-ийг ногоон байгууламжтай болгох ажлыг зохион байгуулах.	эзэмшил газрыг 10%-ийг ногоон байгууламжгүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын судалгааг гаргах. Холбогдох арга хэмжээг авч ажиллах	2024.07.01	Газрын кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн, Сумдын Газрын даамал
1.8	Салбарын албан хаагчдыг газрын мониторинг, кадастр, газар зохион байгуулалт, төлөвлөлтийн чиглэлээр чадавхжуулах сургалтанд хамрагдах	Бүсчилсэн сургалтанд холбогдох мэргэжилтэн нарыг хамруулах	2024.05.01-ний дотор	Газрын удирдлагын хэлтэс
2. ТӨРИЙН АЛБАНЫ ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ				
2.1	Сууц өмчлөгчдийн холбоонд орчны газрыг баталгаажуулах талаар зөвлөмж, мэдээлэл хүргүүлэх, сургалт зохион байгуулах.	Сууц өмчлөгчдийн холбоонд газрын харилцааны талаарх мэдээллийг хүргэж, мэдээллийн сангийн тулгалт хийх.	2024.05.20	Газрын удирдлагын хэлтэс
2.2	"Мэргэжил сурталчлах өдөрлөг"-ийг ЕБС-ийн ахлах ангийн сурагчдыг хамруулан зохион байгуулах.	Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад Газар харилцаа болон барилгын салбарын мэдээллийг хүргэж ажиллах.	2024.05.01	Газрын удирдлагын хэлтэс
3. ТӨЛӨВЛӨЛТЭЙ, ХЯНАЛТАЙ ГАЗАР АШИГЛАЛТЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ				
3.1	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх болон тодотгон боловсруулах ажлыг зохион байгуулах.	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тендерийн дагуу ажлын даалгаврын дагуу хяналт тавьж, хамтран ажиллах	2024.05.01	Ахлах мэргэжилтэн
3.2	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулах	Сүмбэр, Шивээговь, Баянтал сумын Нутаг дэвсгэрийн төлөвлөгөөг боловсруулахад мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, хяналт тавих.	2024.05.01	Ахлах мэргэжилтэн, Сумдын Газрын даамал
3.3	Аймгийн төв болон сумдад гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлсэн газрын зөрчил арилгах, улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулах.	Сүмбэр сумын хэмжээнд иргэдэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлсэн гэр хороололын гудамжийг нэг шугаманд оруулах, цэгцлэх ажлыг зохион байгуулах, газар өмчлүүлэх шийдвэрт өөрчлөлт оруулж, улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулах.	2024.03.20-2024.06.20	Ахлах мэргэжилтэн, Сумдын Газрын даамал
3.4	Тодорхой нутагт дэвсгэрт хэсэгчилсэн төлөвлөгөө хийх ажлыг зохион байгуулах.	Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийтэй холбогдуулан хяналт тавьж хамтран оролцох.	2024.05.01	Газрын удирдлагын хэлтэс
4. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ				
4.1	Еgагаг цахим системийн үйл ажиллагааг сурталчлах нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулах.	3 сумын хэмжээнд нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулах	2024.04.20-2024.05.01	Газрын удирдлагын хэлтэс
4.2	Иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэх.	Аймгийн хэмжээнд газрын харилцаатай холбоотой өргөдлийг цахимаар хүлээн авч 15 хоногт багтаан шийдвэрлэх	2024.01.01-2024.12.31	Газрын удирдлагын хэлтэс
4.3	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудтай газрын төлбөр, татварыг цахимаар төлөх болон газрын үнэлгээний талаарх уулзалтыг зохион байгуулж, газрын төлбөрийн орлого бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион	Газрын төлбөрийн өртэй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын судалгаа гаргах.	2024.04.10	Газрын удирдлагын хэлтэс

	байгуулах.	Сумдын Засаг дарга нартай хамтран ажиллах.		
4.4	"Хариуцлагатай газрын харилцаа аян"-ыг аймгийн хэмжээнд зохион байгуулах.	"Хариуцлагатай газрын харилцаа аян"- төлөвлөгөө боловсруулж Газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллах.	2024.04.20-2024.06.20	Газрын удирдлагын хэлтэс
4.5	Газар эзэмшигч, ашиглагч нарт газартай холбоотой мэдээллийг бодитой, шуурхай хүргэх зорилгоор "Газрын харилцаа" нэртэй подкастыг хийх.	Сумдын 2024 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг танилцуулах.	2024.04.20-2024.05.10	Ахлах мэргэжилтэн
4.6	Газрын харилцааны бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар телевизийн нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэх.	Цойр ТВ -тэй хамтран ажиллаж олон нийтэд мэдээлэл хүргэх.	2024.04.20-2024.05.10	Газрын удирдлагын хэлтэс
4.7	Газар зүйн нэрийг бүх нийтээр ашиглаж хэвшүүлэх зорилгоор иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг газар зүйн албан ёсны нэрийн тухай мэдээллээр хангах, газар зүйн нэрийг зөв бичих, хэрэглэх, хамгаалах аяныг өрнүүлэх.	Сумдын Засаг дарга нарт Багийн шинэчилсэн нэрээр нэрлэж хэвших талаар албан бичиг хүргүүлэх. ГЗБ-н төлөвлөгөөнд батлагдсан нэгж талбаруудыг Газар зүйн нэрээр олгох талаар зөвлөмж өгөх талаар албан хаагчдад болон Сумдын Засаг дарга нарт мэдээллэх.	2024.04.20 2024.04.20	Газрын удирдлагын хэлтэс
4.8	Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан Газар зүйн атласыг сумдын нийтийн номын санд гардуулах.	Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо болон сумдын холбоонд гардуулах.	2024.04.20	Газрын удирдлагын хэлтэс
4.9	Албан хаагчдын дунд газрын харилцааны ойг угтан өрөө тасалгаагаа тохижуулах аян зохион байгуулах.	Албан хаагчдын дунд "Бидний өрөө - Хамгийн цэвэрхэн" аянг зохион байгуулах.	2024.04.20-2024.05.05	Газрын удирдлагын хэлтэс
5. САЛБАРЫН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ				
5.1	2025 онд хос бичигт шилжихтэй холбогдуулан нийт албан хаагчдыг монгол бичгийн сургалтад хамруулах.	Байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулж, өөрийн чиглэлийн дагуу албан тоотыг хос бичгээр гаргах ажлыг зохион байгуулах.	2024.10.01 хүртэл	Газрын удирдлагын хэлтэс
5.2	Газрын харилцаа - Таны хотонд" аяныг зохион байгуулах.	"Газрын харилцаа - Таны хотонд" аяны төлөвлөгөө боловсруулан Газрын даргаар батлуулан хэрэгжилтийг хангах.	2024.04.01-2024.05.20	Газрын удирдлагын хэлтэс
5.3	Салбарын албан хаагчдын дунд урлаг, спортын наадамд оролцох.	Газрын харилцааны салбарын баярын өдрөөр урлаг, спортын наадамд орон нутгаас оролцох.	2024.05-р сард	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
5.4	Газрын харилцааны салбарын талаарх мэдээлэл бүхий тохимол хэвлүүлэх.	Сумдын "Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ийг ажлын хэсгийн гишүүдэд хэвлүүлж өгөх, дадлага ажил хийх.	2024.05.10	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
5.5	Сайн үйлсийн аяныг зохион байгуулах.	Өвөлжилт, хаваржилтийн хүндрэлтэй үед Сүмбэр сумаас малчин өрх сонгон шар усны үер болон малын сэг зэмийг устгах ажилд туслах ажлыг зохион байгуулах.	2024.03-04 сард	Газрын удирдлагын хэлтэс

төлөвлөгөө боловсруулсан:

ГАЗРЫН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Э.БАЯРМАГНАЙ